




Шинэ номын танилцуулга:

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН

Номын нэр:

Гадар хавтсан дээр: MONOGRAPH SERIES, Volume 6, АНТООН МОСТАЭРТ МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ. МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН, Улаанбаатар, 2014.

Дотор хавтсанд: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв

Карлын Их Сургуулийн Гүн Ухааны Факультет Өмнөд ба Төв Азийн Судлалын Институт, **МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН** (Монгол Улсын Нууц Түүх), Жүгдэрийн ЛУВСАНДОРЖ.

Номын бүтэц

Нэгдүгээр хэсэг: Монголын Нууц Товчооны (цаашид МНТ гэж товчилно) **халх-монгол орчуулга** (хуудас 5-134)

Хоёрдугаар хэсэг: МНТ-ны хэлбичиг соёлын тайлбар (хуудас 135-550)

МНТ-ны тайлбарын дагалт (хуудас 551-571):

1. Хураасан үг
2. Томьёолсон тэмдэг
3. Хэлбичиг соёлын нэр томьёо (монгол-англи)
4. МНТ-ндхи хэлэхийн задлаг загвар
5. Найруулгын маягууд ба тусгай тэмдэглэлүүд

6. МНТ-ны тайлбарт эшилсэн ном зүй

Танилцуулга

“Монголын Нууц Товчоон” бол монголын түүх уран зохиолын хосгүй дурсгал төдийгүй дэлхийн уран зохиолын бүрэлдэхүүн хэсэг гэгдэж байна. Тийм болохоор одоогийн монгол хэлээр ар өвөр монголд 10 гаруй удаа, гадаадын 26 орны хэлээр орчуулагдан гарсан байна.

Энэ олон орчуулга бол бүгд монголын түүх уран зохиолын судлалд өөрийн хувь нэмрийг оруулсан чухал бүтээлүүд болох нь маргаангүй.

Гэвч эдгээр орчуулга бүгдэд нэгэн хэвийн цутгамал мэт олон алдаа эндүү давтагдаж байдаг юм. Алдаа эндлийн тоо хэдэн арваар биш, олон зуугаар тоологдоно. Яагаад ийм болсон бэ гэдгийн товчхон хариу гэвэл МНТ-ны хятад галигтхи буруу уншилга, мөр хоорондын хятад хадмал тольдхи буруу орчуулгаас болов. Энэ тухай арай дэлгэрэнгүй тайлбарлая.

- МНТ-ны уг эх нь монгол бичгээр байсан. Түүнийг хожим хятад авианы үсгээр, монгол хэлээр галиглан бичсэн. Үүнийг одоо *хятад галиг*, *ханз галиг* гэж нэрлэж байна. Энэ галигийг Нууц Товчоон гарснаас хойш 60 жилийн дараа хийсэн, 150-иад жилийн дараа хийсэн гэх хоёр зүйлийн санал байдаг.
- МНТ-ны хятад галигаар бичсэн үг бүрийн хажууд хятад орчуулга хадсан байдаг. Энийг *хятад хадмал*, *мин хадмал*, *мөр хоорондын хадмал орчуулга* гэх мэтээр одоо нэрлэж байна. Энэ хадмал толийг МНТ гарснаас хойш 150 орчим жилийн дараа Мин улсын хааны зарлигаар хятад хүнд монгол хэл суралцах гарын авалга болгож хятадад өсөж төрсөн хоёр монгол эрдэмтэн хийсэн гэдэг.
- МНТ зохиолыг 282 зүйл болгон бүлэглэж зүйл бүрийн эцэст уг зүйлийн агуулгыг маш товчхоноор хятад хэлээр орчуулсан байдаг. Үүнийг *товч хятад орчуулга* гэж нэрлэж байна.

МНТ зохиолын хятад хэвлэл ийм гурвал бүтэцтэй олдсон болохоор тэр гурван бүтэц бүхий номыг МНТ-ны *хятад эх* гэж, хэлий нь *уг эхийн хэл* (Original Tongue) гэж Нууц Товчооны судлагчид нэрлэж заншсан юм. Ингээд “МНТ-ыг *уг эхийн хэлнээс орчуулсан Ф. В. Кливез*” гэх мэтээр номынхоо нүүрт бичдэг байна.

Нууц Товчооны уг эхийн хэл гэдэгт дээрх гурван зүйлийг багтаадаг явдлыг би үзэл баримтлалын алдаа гэж үзэж байна. Нууц Товчооны *уг-эх*, *уг эхийн хэл* гэвэл зөвхөн уйгуржин монголоос буулгасан хятад галиг мөн болно. Хожмын хүний хийсэн *хятад хадмал*, *товч хятад орчуулга* хоёрыг уг эхэд тооцож болохгүй.

Гэтэл орчуулагчид яагаад эх монгол хэлнээс нь орчуулахгүй хятад хэлнээс орчуулдаг вэ гэсэн асуулт тавигдана. Үүний хариуг би ингэж үзнэ:

Уг эхийн уйгуржин-монгол бичвэр маш хэцүү, ойлгохуйяа бэрх мартагдсан үгс олонтой юм. Гэтэл хажуугийн хятад хадмал орчуулга бол хятад ярианы хэлээр бичсэн ойлгоход хялбар байна. “Тухайн үгэнд хажуугийн хятад хадмал байгаа л бол түүнийг баримтлахгүй байж үл болно” гэсэн барууны эрдэмтэн багшийн заавар ч байдаг юм. МНТ-ыг өрнөдийн хэлээр орчуулсан хүмүүс бол алдартай хятадач эрдэмтэд байдгийн учир ч тодорхой болно.

Нууц Товчооны хэл бол одоогоос 800 жилийн тэртээх манай өвгөд дээдсийн хэл. Одоогийн монгол хэлнээс олон зүйлээр өөр. Түүнээс гадна маш эртний аман бичгийн хэлний үг хэлц олныг хадгалсан хэл юм.

Нууц Товчоог хадгалсан уйгуржин бичиг бол 2-4 тусгай авиаг дунд нь нэг үсгээр бичдэг үсэг олонтой. Түүний дээр ямар ч цэг тэмдэг хэрэглэсэнгүй бичвэр байсан. Тэгээд бас тийм бичвэрийг өөр бусад аялгуутан хүн уншиж галигласны учраар эндүү

ташаа уншилга маш олон болж, тэр нь цааш буруу ойлголт, буруу орчуулгад хөтөлсөн гэж би үзэж байна.

Энэ тухай бүр тод хэлбэл Нууц Товчооныг зүүн монгол аялгууны хүн бичсэн. Түүнийг баруун юмуу өмнөд монгол аялгууны хүн уншиж хятад үсэгт оруулсан юм. Түүнээс гадна анхаарвал зохих нэг онцлог үзэгдэл бол уйгуржин-монгол бичигт нутгийн аялгууны хувилбар үсэг байсан ядал байна. Хувилбар үсэг гэж юуг хэлж байна? гэвэл, *Арын са*, *Өврийн са* гэдэг нэртэй нэг үсгийн хоёр өөр дүрийг хэлж байна. Монгол бичгийн *с* үсгийг зүүн монголд (барга буриад) *ч* үсгээр бичээд *с* авиагаар уншдаг. Уламжлалт нэр томъёогоор нь хэлбэл, барга буриад аялгуутан монгол бичгийн *са* үсгийг *арын са* гэж, түүнийг *ча* үсгийн дүрээр бичсэнийгээ *өврийн са* гэж нэрлээд *са* үсгээр уншдаг юм.

Жишээ нь *бачаган* гэж бичээд *басаган* гэж дуудна. Ингэж *арын са* үсгийг *өврийн са* үсгээр сольж бичсэн үгс Нууц Товчоонд олон байна. Тэр *с* үсгийг хятад галигч *ж/ч* үсгээр уншсан хачин үгс нэлээд байна. Зарим жишээ:

- *Чэчэгэй өндөр* (сэсэгэгэй өндөр, цэцэгийн өндөр) гэдэг уулын нэрийг *Жэжэжэр өндөр* (§166) гэв. Одоогийн Богд-хан уулын нэр бололтой.
- *Сарана хавцгай* (сараанаг/хуухнаг хавцгай – ‘мухар хавцгай’) гэдэг газрын нэрийг *Чэрэнэ хавцгай* гэж бичив. Тэрнийг Дамдинсүрэн *Зээр/зээрэн хавцгай* (§129) гэв.
- *Их-Саран* гэдэг хүний нэрийг *Их-Чэрэн* (§51) гэв. Түүнийг *Их-Цэрэн* гэсэн нэрээр эндүүрэх явдал гарсан.
- *Архас!* (гялс-манас!) гэдэг дүрслэх үгийг *архач* (архача – §72) гэж бичээд хятад хадмал орчуулгад *төлөвлөгөөтэйгөөр, санаатайгаар* гэв. Ингээд энэ үгийг *аргаас, аргаар, нэг арга байна* гэх мэтээр тааж орчуулцгаав.

Үсэг эндүүрч уншсан, эр эгшгийг эм эгшиг болгон уншсан, “эгшиг + г + эгшиг” цугцыг урт эгшгээр эндүүрсэн зэргийн жишээнүүд олон бий. Тэрнээс заримыг үзүүлье.

- Монгол бичгээр (цаашид *мо-би*. гэж товчилно) *тохоба* (тохов ‘тавив’) гэдэг үгийг урт эгшигт үг болгож *туув* (§63) гэж уншаад *буув*, *суув* гэсэн орчуулга өгөв. Ингээд Дэй Сэцэний зүүд: “*шонхор шувуу нар сар хоёрыг атгаж ирээд гар дээр тавив*” гэсэн утгатай өгүүлбэр *гар дээр суув* гэсэн орчуулгатай болов.
- *Мо-би. гозжогор* (гозгор) гэдэг үгийг *хүчүгүр* (§89) гэж бичив. Тэгээд *хээрийн хулгана* гэсэн орчуулга тавив. Ингээд Тэмүжин нар *тарвага гозгор* алж идсэн тухай бичвэрийг *тарвага ба хулгана* алж идсэн гэж орчуулцгаав.
- *Мо-би. гулгиад* (гулгиагууд, гулгиа юмнууд) гэдгийг монгол бичгээр *гулугад* гэж бичсэн байсан бололтой. Тэр үгийг хятадаар *хулугад* (§79) гэж бичээд *муунууд*, *муучууд* гэх орчуулга тавив. Ингээд *гулгиа юмнууд гуужив, шүлхий юмнууд сэврэв* гэх өгүүлбэрийн *гулгиагууд* гэдэг үг *гологдол, өөдгүй юмнууд, хурганууд, зулзган шувуу, хулхи нь онгойлоо* гэх мэтийн хачин орчуулгаар гарав.
- *Мо-би. хуйиба* (хуйв) гэдэг үг бас *хуби* гэсэн хувилбар бичилгээр гардаг. Ингээд *хурдан хуби* (хурдан хуйв – §90) гэдэг хөлөг морины нэр хятад хадмалд *цайвар хүрэн морь* гэсэн орчуулга тавигдав. Тэгтэл судлалч эрдэмтэн энэ үгийг *хуба* гэсэн түрэг үг, төгсгөлийн *-ба* үсэг нь *-ла* үсэгтэй сэлгэж *хул* гэх үг болсон гэв. Зарим эрдэмтэн цааш нь, *хуба* (шарга морь) гэдэг үг *-и* дагаврыг авсан болохоор эм хүйсийн *хуби* (шарга гүү) гэсэн үг гэж орчуулж тайлбарласан зүйл бий. Ингээд монголын *сайн эрс гүү унаж явсан* гэх эвгүй орчуулга гарсан юм.
- Ер нь хөлөг морины нэрсийг хятадаар тун тусгүй орчуулсан. Бас жишээ:

Мо-би. *орог шунгал* (орог = орогч, дайрагч; шунгал = шунгагч) гэдэг морины нэрийг *орог* – (цайвар өнгө), *шунхал* – (хар голтой) гэж горигүй орчуулсан юм.

Уйгуржин-монгол бичгийн үгийн эцсийн богино сүүл (-с үсэг, заримдаа агишилга)-ийг урт сүүл (-н үсэг)-ээр эндүүрсэн уншилгын жишээ

- *Сахал биес эсэн атугай, сал уяж орё* (§105) гэдгийг *сахал баян эсэн атугай сал уяж орё* гэж уншив. *Сахал баян* гэдгийг хятад хадмалд *сахал өвс/зогдор өвс* гэв. Ингээд монголын цэргүүд өвсөөр сал хийсэн тухай үлгэр гарсан.
- *Мэргэдийн чургааг гэрийг цоолж, цохтой эмсийг олзолж* (§115) гэсэн шүлэг бий. *Чургааг* (шургааг) гэх үгийг *чурган* гэж уншаад хадмал орчуулгагүй орхисон юм. Ингээд мэргэдийн *цоргон гэр, оцгор гэр, цуурхай гэр, шовх гэр, цоожтой хөсөг, цуургатай тэрэг* гм. хачин орчуулга тайлбарууд гарав.

Цэг тэмдэг тавиагүй үсгийн эндүү уншилга

-Эхний на үсгийг а үсгээр уншсан:

- *өвсний налархай* (§88) гэдгийг *өвсний алархай* гэж уншив. *Налархай* гэж унших ёстой гэдгийг *налу-* гэдэг үйл үндэс нь зааж байна.
- *Налиах болон* (нялганах, зусардах гээд, §140) гэдгийг *ариах болон* гэж уншиж бичээд хадмал орчуулгад *шийдэмгий биш байх, итгэлгүй байх* гэсэн орчуулга хадав. Ингээд *ядах, эргэлзэх* гэх мэт тусгүй орчуулга гарсан.
- *Нятрах хуцал* (нохойн тухай: *айсан, нятарсан хуцал* – §189) гэдгийг *идүрэхүй хуцал* гэж уншаад тэр үгэндээ (*гай зовлон*) *дөхөж ирэх* гэж хадмал орчуулга тавив.
- *Няхуурхалдан чивчээрэлцэн* (чивчрүүлэлцэн) *бүхийд* (§143) – (*өөр өөрсдийн цэргийг журамлан зангидаж байхад* = *маневралцан байхад*) гэдгийг *ихургалдан жившээрэлцэн бүхийд* гэж уншив. Тэгээд хятад хадмалд *ихургалдан* гэдгийг *ухралдах* гэж, *жившээрэлцэн* гэдгийг *цэгцлэх, журамлах* гэж орчуулав. Ингээд “Хүйтэн гэдэг газар маш их дайн болсноор” орчуулж тайлбарладаг байна.
- *Нялгадах* (§188) – *ус шаварт нялгадах, хөрвөөх* гэдэг үгийг *илагаадах* (ялаатах) гэж галиглаад *ялаанд хазуулах* гэж хятад хадмалд орчуулав. Уйгуржин-монгол бичгээр *ялаа* гэдэг үгийг *илага* гэж бичихээс *илуга* гэж бичдэггүй. Ингээд *усархаруун хулад нялгадаж байхыг үзээд* (*усанд ханасан хулангууд усанд хөрвөөж байхыг үзээд*) гэх хэлц: *ус эрсэн хулангууд ялаанд хазуулж байхыг үзээд* гэсэн горигүй орчуулгууд болон хувирав.
- *Ноёны сэтгэл* (ноён зан, §181) гэдгийг *үений сэтгэл* гэж уншив. *Үений* гэдэгтээ *хуучин, урьдын* гэж хятад хадмал орчуулга өгөв. Ингээд энэ үгийг *хуучирсан сэтгэл, үжирсэн сэтгэл, өгөр сэтгэл* гэх мэтээр гөрдөн орчуулцгааж *Дагуур* зэрэг аялгуунаас үг олж тайлбарлахыг оролдоцгоов. Нууц Товчоонд “*Ноёгдай ноёмсог зантай тул ноёхон овогтон болов*” (§46) гэсэн жишээ байгаа нь *ноён зан* гэж ойлгохын баталгаа болж өгнө.

Хар ярианы үгийг эндүү уншсан жишээ

Нууц Товчоон бол сонгодоогоос өмнөх монгол бичгийн хэлээр бичигдсэн зохиол. Гэвч тэр үеийнхээ хар ярианы хэлний уран өгүүлэх чадамжийг шигтгээ болгон чимэглэсэн тохиол олонтой юм. Эртний ярианы тийм зарим үг одоо ор тас мартагдсан боловч үлдсэн синонимоос нь яг таг сэргээх боломжтой байна. Нэг тийм жишээг хэлье:

- Жамухагийн эцсийн үгэнд: “Их *эмээтэй* бөлгөө би (§201),
Андаас алсыг сэтгэх гэсээр байгаад
Алдас болов би.”

гэж хэлэв. *Эмээ* гэгч мартагдсан үг бол *эмэгэ* (өвчин) гэдэг үгний хар ярианы товчлол юм. Одоогийн халх ярианы хэлэнд *өөөө* (өвчин) гэх товчлол дүрээрээ байна. Ингээд *Их эмээий бөлгөө би = их өөөтэй хүн билээ би* (их солиотой/хэнээтэй/өвчтэй хүн шүү би) гэсэн хэлц болно. *Эмээ* гэдгийг монгол бичгээр *эмэгэ* гэж бичсэн. Тэрнийг хятад хадмал орчуулгад (*хөгишин*) *эм* гэв. Ингээд бүх орчуулгад *олон эмэг эхтэй, олон зөнөсөн эмээтэй, олон эхнэртэй, олон зарц эмстэй, арвин гэм зэмтэй...* гэх мэтийн ташаа орчуулга тайлбар гарав.

Түүхэн үгийг эндүү ойлгосон жишээ

Монголын олон аймаг үндэстний түүхийг эзэлсэн, нэн эртний уламжлалтай, аман бичгийн үгс Нууц Товчоонд цөөн биш байна. Тэрний нэг нь *Эл/ил* (мо-би. *элэ*) гэдэг үг юм. Энэ үгийн эртний утга нь *эзэн, хан, ноён, эрхэм* гэх үгсийг орлоно. Одоогийн хэлэнд бараг бүрэн мартагдсан боловч *элбэг, элбэрэл, элч, элчин, элэгсэг, элэгсэ-* зэргийн үгэнд язгуур үндэс нь хадгалагдаж байна.

“БНМАУ-н Түүх” номын мэдээгээр бол *элэ* гэдэг үг жужан хэлнээс түрэгт орсон. Түрэг улс эзэн хаанаа *элэ* гэж нэрлэсэн. Түрэгийн үед *эзэн, хан, аймгийн холбоо, улс* гэх зэрэг олон утгатай үг байсан. Киданы хааны удамд *элүй* гэх үг байх ба *илижин* (эл эзэн) гэх цол байсан. Их-Монгол Улсын хааны тамгад *ил булха иргэн* (нөхөр ба дайсан улс) гэсэн үг байгаа. Иранд суусан монгол хаадыг *Ил-Хан* гэж нэрлэж байсан зэргийн баримтаас үзвэл монгол гарлын үг бололтой. Нууц Товчоон дахи хэрэглээний зарим жишээ:

- *эрс /эрчүүл сайчуул болон өсөөд эрэлхэг овогийн Эл (=найдвар, түрүү, толгой, тэргүүн, хан, эзэн) болов (§75.2).* Энэ хэлц бол Тэмүжин нар зовлонт амьдралд өсөөд одоо *эрэлхэг овогийн тэргүүн болов* гэсэн санаа юм. *Элэ* гэдэг үгийг хятад хадмал орчуулгад “тодорхойгүй сул үг – тэр хэртэй, орчим” гэх утгатай гэв. Ингээд энэ хэлц... *эрэлхэг омогтой л болов, эрхүү омголон болов, эрхэт омогтон л болов* гм. тусгүй орчуулгаар гарав.
- *зөв элэ! (зөв /зүйтэй, ноёнтон! – “зөв жентлемен!”), §82.5).* Энэ бол Тайчуудын мөрдөлгөөс нуугдан Ононы усанд хэвтсэн Тэмүжинийг Тайчуудын Сорхон-Шар үзээд дуу алдсан үг юм. Монгол орчуулгуудад: *зөв дөө, зөв л* гэж орчуулсан аж.
- *ядах мэт эл бий юу чи (ядсан ч эзэн бол доо чи! – §194.38) – ийм ч эзэн байх гэж дээ чи!;* Энэ үг бол Найман улсын цэргийн ноён, өөрийн эзэн хааныг голж хэлсэн үг юм. Монгол хэлний орчуулгуудад: *ядах л мэт буюу чи, ядах мэт энэ буюу, ядах мэт л буюу чи* гэж хачин орчуулцаажээ.
- *Эл ээ, тийм бөгөөс (ноён оо, тийм бол – §195.48).* Энэ үг бол Найманы Даян-хан Чингис-Хааны армиас ихэд айж Жамухагийн үгэнд олон удаа дуу алдсан хэлцэд гарна. Монгол орчуулгуудад *энэ тийм бөгөөс, тийм л бөгөөс* гэж “амтгүй” орчуулсан.

Үгийн тохирох утгыг олсонгүй алдаанууд

Хэлний нэг үгнээс түмэн утга цацарна гэж ардын үг байдаг. Үг, хэчнээн зүйлийн утга цацрааж байвал тэр үгийг тэр хэлний жинхэнэ паспорттой үг гэж хэлсэн мэргэдийн зүйрлэл байдаг. Үгийн олон утгад:

- ижил дуудалгатай мөртлөө өөр өөр утга гаргадаг үгс,
- ижил бичилгэтэй мөртлөө дуудалга утга нь өөр үгс,
- бусад үгийг төлөөлөн хэрэглэгдэж явдаг төлөөлөл үгс,
- утга нь шилжээд зүйрлэл болсон үгс,
- өвөрмөц хэлц,
- этгээд үгс

гэх мэт тоогүй олон утга байдаг. Эдгээрийн учрыг зөв олж тодорхойлоход монгол үндэстний түүхээр тогтсон соёл, этно-коммуникаци (харилцааны этнографи), амьдрал аж төрлийн хэв маяг, монголын нүүдэлчдийн бодох сэтгэх арга зэрэг хоорондоо нөхцөлдсөн холбоонд нь судалж байж зөв утгыг олж болно. Тэдгээрээс ноцтой заримыг энд жишээгээр ярья:

- **Өлзийтөн хэвтүүл** (өлзийгөө/ач буянаа өгсөн хэвтүүл = намайг амгалан унтуулагч хэвтүүл) гэсэн Чингис-Хааны үг (§230)-ээр эхэлье. Монгол хүнд бол энэ хэлц ойлгомжтой, тайлбар, орчуулга ч хэрэггүй. Хятад хадмал тольд **өлзийт** гэдэг үгэнд *аз жаргалтай* гэсэн орчуулга өгсний учраар гадаадын хэлнүүдэд польш, францаас бусад нь **миний аз жаргалтай шөнийн харуулууд** гэж муу орчуулсан. Хааны хэвтүүл цэрэг бол чухамдаа зовлонг тэсвэрлэгч хүмүүс юм.
- **Урт дөрийн хүмүүс** (§191) – үндсэн утга: *малчны үг: урт оосор дөртэй хүмүүс*, шилжмэл утга: *энгийн ард, малчин ард*. Хятад хадмалд *энгийн ард* гэж зүйрлэл утгаар нь зөв орчуулсан. Гэтэл энэ хэлцийг латин галигч нар **уту дурын хүмүүс, үтү дүрийн хүмүүс** гэж буулгасан (хятад галигч *у, ү* хоёрыг ялгахгүй)-ы учраар хачин янзын ташаа орчуулга тайлбар, судлалуудыг даглдуулсан хэлц болон хувирсан юм. Жич: **урт** гэдгийг одоо ч буриад аялгуунд **ута** гэдэг байна.
- **Мэхээрчилэн тата-** (§140) – үндсэн утга: хүний нурууг мэхээр хэлбэрт оруулан тата- (= хүний нурууг нумруулан тата-). Энэ хэлцийг Нууц Товчооны эх бичвэрт **мэхэчилэн тата-** гэж бичив (тэрнийг хятад галигч **мэгэжилэн тата-** гэж буулгав). Ингэж үгийн эцсийн зарим гийгүүлэгчийг дагаврын өмнө хаях тохиол эрт одоогийн мо. хэлэнд байна (*өндөт гар-* < өндөрт гар-, Нууц Товчоон). **Мэгэжилэн** гэгч хачин үгийг хятад хадмалд **барьж авах** гэж тааж орчуулав. Монгол хэлний орчуулагчид **мэхийлгэн татаж** гэв. Энэ бүр тохирохгүй юм. Ингээд энэ хэлцийг зөв орчуулсан орчуулга үгүй болов.
- **Хуул-** (амьтны арьсны тухай: *хуу ав-, хуулж ав-, бүх арьсыг хуу татан ав-*) гэх үгийн шилжмэл утга: *давхи-, довтло-, дайран оро-, эзлэн ав-* гэсэн утгаар Нууц Товчоонд олон удаа гардаг идиом. Ачин гөрөөчин байхаас уламжилсан түүхэт идиом мөн.
--Жишээ: **Бид тэднийг хуулъя** (=довтолъя, §35), **харуулаас хүн хуулан ирж** (=довтлон ирж, §142);
Хуул- гэдгийг хятад хадмалд **булаан ав-** гэсэн болохоор гадаад хэлэнд **дээрэрэмдэ-** гэх эвгүй өнгө аясаар орчуулсан. Зарим латин галигч энэ үгийг **ha'ul-** гэж буулгасныг монгол хэлний орчуулагчид дагалдаж **уулгала-** (уухай хашгиран дайра-) гэж муухай орчуулцгаасан юм.
- **Хуулга** гэдэг нэр үг бас гарна. Утга нь **хуулж авсан юм** = мал амьтны **арьс**. Шилжмэл утга нь хүний тухай, **турсага, “муу арьс”** (модал доромж). Энэ үг Нууц

Товчоонд 4 удаа энэ л утгаараа гарсан. *Хуулга* үгийг хятад хадмалд *зам, ховил зам* гэж, зарим удаа орчуулгагүй орхисон юм. Ингээд гадаад хэлэнд, --*хавиргадаа арьс /турсага болтол бүжиглэв* (§57) гэх хэлцийг *хавиргадаа зам мөр болтол бүжиглэв, газрыг хавиргадаа хүртэл хонхор болтол бүжиглэв* гм. гажиг орчуулсан байна.

--*Гоо Үжин эхийн гогод мангираар тэжээсэн хуулаа (турсган) хүүхдүүд хууль тогтоох хүмүүс болов* (§75) гэдгийн *хуулаа хүүхдүүд* гэдгийг *хурдан шаламгай хүүхдүүд, давхилдаж яваа хүүхдүүд, өлсгөлөн гонгиноо хүүхдүүд* (Рахевилз) гм. горьгүй орчуулсан байдаг.

Ерөнхий нэрээр тусгай нэрийг төлөөлүүлэх ёсны тухай

Үгийн утгыг шилжүүлэн холбируулж нэгийг нөгөөгөөр орлуулан нэрлэх явдал бол хэл бүгдэд байдаг үзэгдэл. Маш олон дүр янзаар илэрнэ. Үүнээс Нууц Товчооны хэлэнд *ерөнхийгөөр тусгайг* орлуулсан *төлөөлөл* (метоними) үг онцгой анхаарлыг татна.

- Жишээ: *шувуу* гэдэг ерөнхий утгат үгээр *шонхор* гэдэг тусгай нэрийг төлөөлүүлсэн тохиол Нууц Товчоонд хэдэн удаа гарна.
Чингис-Хаан, Боорч Мухулай хоёрт хэлж байна: Та хоёрт Хитадын хил сахигч иргэнийг хувааж өгье. “Та хоёр тэдний язгууртан хөвүүдээр нь *шувуугаа бариулж дагуулж явагтун*. Язгууртан охидоор нь эмсийнхээ хормойг засуулж байгтун” (§266) гэв. Энд *шувуу* = *шонхор* аж. Бас Есүхэй-Баатар Онон мөрөнд *шувуулан явж* байтал Мэргэдийн Их-Чилэдү охин авч явахтай дайралсан (§54). Энд *шувуулан* гэдэг нь *шонхор тавьж гөрөөлөх* гэсэн утга гаргав. Ийм ерөнхийгөөр тусгайг төлөөлүүлэх жишээ одоо ч бидний ярианд байна. Ж. *цаас* гэдэг үгээр *төгрөг, валют* гэсэн үгийг төлөөлүүлдэг шүү.
- Яг ийм төлөөлөл МНТ-ны хэлэнд *иргэн* гэдэг үгэнд байна. *Иргэн* гэдэг үгийн үндсэн утга нь *хүн, ард* юм. Гэвч төлөөлөл утга нь *улс, улсын хаан, ноёд, эрхтэн дархтангууд* гэсэн утгаар тэр цагийн монгол хэлэнд хэрэглэгдэж байсны баримт бол Нууц Товчоон юм. Зарим жишээ:
--*Эр өшөөт Мэргэд иргэний элэгий нь эмтлэв, өврий нь хоослов, ургийн хүнийг хядав* (§113). Энд *Мэргэд иргэний* = *Мэргэд хаадын* (ерөнхийгөөр тусгайг төлөөлөл) болно. *Иргэн* гэдэг үгийг хятад хадмалд *ард харцас* гэж орчуулж өгсөн болохоор гадаад ба мөн монгол хэлний орчуулгууд *мэргэд иргэдийг алж хядсанаар л* орчуулдаг байна.
--Дээр гарсан өгүүлбэртхи *Мэргэд иргэний ургийн хүнийг хядав* гэдэг бол *мэргэд хаадын ургийн хүнийг хядав* гэж ойлгох ёстой холбоо үг болно.
- Нууц Товчооны §154: Татаар улсыг сөнөөгөөд Чингис-хаан “*улс иргэний нь* (= хаад ноёдыг) яах вэ?” гэсэн асуулт гарсанд ургаараа нэг гэрт орж нууц зөвлөлгөөн хийсэн. Ургийнхан хэлэв: *Татаар иргэн* (= хан язгууртнууд), бидний өвгөд дээдсийг барсан. Одоо тэднийг тэрэгний дугуйд чацуулан бүгдийг хядъя” гэсэн шийдвэр гаргасан. Ингээд бүх орчуулга *татаарын иргэдийг* буюу ард түмнийг тэрэгний дугуйд чацуулан хядсан гэж орчуулцаасан юм.
- Бас нэг тусгүй очуулга – §268: “*Тангуд иргэн* (=хаан) үг өгүүлж, үгэндээ үл хүрэхийн тул *тангуд иргэнд* (= улст, хаанд) Чингис-Хаан хоёртхи удаа аялж *тангуд иргэнийг* (=хааныг, улсыг) мохотгож ирж...
Энэ хэлцийг бүгд махчилан орчуулдаг.”*Тангудын бүх хүнийг алж устгасан. Бүр эцсийн боолыг хүртэл устгасан* (Козин), Кливез, Рахевилз нарын англи орчуулга ч адил. Энэ бол Нууц Товчооны товч хятад орчуулгыг дагасан түүхийн гуйвуулга-орчуулга юм.

Мартагдсан өвөрмөц хэлц

Яст хүн (мо-би. *йасуту күмүн*) гэгч өвөрмөц хэлц эрт мартагдсан бололтой. Үлдсэн утга нь *хан яст хүн, цагаан яст хүн, ясан төрөл* гэх мэт үгэнд байна. Нууц Товчооны *яст хүн* гэдэг нь *язгууртан, сурвалжтан, хан язгууртан* гэсэн үг юм. Жишээ:

- **Чингис-Хаан, тайчуудай яст хүнийг... ургийн урагт хүртэл үнсээр хийсгэн хядав** (§148) гэж бий. **Яст** гэдэг үгийг хятад хадмалд *угсаатан, овогтон* гэв. Ингээд *тайчууд угсаатныг хядсан* гэх муухай орчуулгууд гарав. **Тайчуудай** үг бол *тайчуудын* гэсэн үг болно. Монгол хэлэнд Ц. Дамдинсүрэн анх *тайчуудын язгууртныг хядсан* гэж зөв сайн орчуулсан боловч дараахи хүмүүс түүнийг орхив.
- **Эл яст хүн** (= хан яст хүн, хан язгууртан) – §112 гэх өвөрмөц хэлц байна. **Эл** (элэ) үг энд *хан* гэх утгаар байгааг батлах хэлц юм. Жишээ:
–Бэлгүдэй ноён мэргэдийн эл яст хүнийг “эхий минь авчир” гэж годилдох бөлгөө гэж гарсан. Монгол хэлний орчуулагчид: *мэргэд овгийн хүнийг үзвэл, мэргэд яст хүнийг, мэргэдийн л яст хүнийг* гэх мэтээр бүр хүч нэмэгдүүлэн буруу орчуулсан байдаг.

Мартагдсан утгын бас нэг үг

- **Харь, харин** (мо-би. *хари, харин*) гэгч ноцтой өвөрмөц хэлц (§129) байна. **“Жамуха тэргүүнт Задран 13 харин нөхцөж 3 түмт болж”** гэв. Энэ үг бол *харимал эхнэр, харьж асгарах* гэх мэт үг хэлцэд санаа нь байгаа, *харимал /урвалган аймгууд, харин няцагсад, салан тусгаарлагчид* гэх утгыг үзүүлнэ. Тайчууд, Задран зэрэг монгол аймгууд бол Есүхэй-Баатарыг үхсэний дараа салан тусгаарлах санаатан болсон түүхтэй юм.
Харь, харин гэдэг үг Нууц Товчоонд **1)** өөр овог аймаг, **2)** урван тэрслэгчид, **3)** гадаад дайсан улс – ийм гурван утгаар гарна. Аль тохирохыг хам бичвэр заана. **Харин** гэдэг үгийг хятад хадмалд *овог, аймаг* гэсэн нь эхийн зөв санааг гаргахгүй.

Гар бичмэл ба үзэг цаасны явдал

Нүүдэлчдийн цаас, бэхний чанар муу байсан. Гараар хийсэн хулсан үзгээр бичихэд үсгийн хурц өнцөг, дугуй булан гаргах зэргийн зурлагын төвөгөөс зарим үсгийн дүр адил харагдах явдал байдаг байсан. Энэ нь зарим эндүү уншилгын үндэс болдог. Түүнээс гадна бичиг дэвтэр олон жилийн хадгалалтад үсэг, үсгийн хэсэг балрах эвдрэх удаа ч байсан. Би энд жишээ болгож *бусанхаж* (бусниулж) гэдэг үг хэрхэн *бучалгаж* (буцалгаж) гэх үг болсныг ярьж.

Уйгуржин-монгол бичгийн *бучангхажу* гэдэг үгийн дундхи *нг* (үсгийн нэр нь *их инхэлиг*) үсгийн бүтэцэдхи *нг* үсгийн нуман зурмын толгойн хэсэг баларч алга болсноос *л* үсгийн эвэр гэдэг зурамтай адил харагдаж байсан. Тэгээд тэр үгийг дараагийн хуулан бичигч *бучалхажу* (буцалгаж) гэж уншсан. Ингээд Нууц Товчоондхи **“Чонос овгийн хунтайж нарыг Далан Тогоод гэдэг газар бусниулж”** гэх утгатай өгүүлбэр – **“Чонос овгийн хөвүүдийг Далан Тогоод буцалгаж”** (§129) гэх ташаа уншилга төрсөн.
Бучалгажу үгийг хятад хадмал орчуулгад *буцалгах, тогоонд буцалгах* гэсэн. Энэ эвдэрсэн бичилгэ Нууц Товчооны уг эхээс гадна, бас бусад түүхийн сурвалж бичигт давтагдсан тул монгол ба гадаад бүх орчуулгад нэг загварын алдаа болон гарав.

Зарим орчуулагч **буцалгав** үгийн өмнө **амьдаар нь** гэх үгийг нэмж **амьдаар нь буцалгав** (Рахевилз) гэж “тодруулсан” байдаг.

Ингээд “монголын хаад, дайсан хүмүүсийг амьдаар нь тогоонд чанаж байсан” гэх орчуулбар улиг домог болж дэлхийд тарав (ВВС-ийн баримтат кино *Чингисхан*). Амьд хүнийг, тэр тусмаа 70 тогоонд буцалгах явдал бол нүүдэлчдэд болгоё гэсэн ч боломжгүй зүйл юм. Нууц Товчоонд дайснаа дарсан тухай бичихэд “**дайсан аймгийн нэр + -ийг бусанха-**” гэсэн тогтсон хэлцийн загвараар бичсэн юм. Жишээ: **Мэргэд иргэнийг бусанхаж** (§113), **Найман, Мэргэд бусанхагдав** (§208), **Мэргэд, Найманыг бусанхах зуур** (§208). Яг л энэ загвараар бичигдсэн өгүүлбэр байжээ. Жич: **бусанха-** үгийг **бучанха-** гэж бичсэн нь дээр ярьсан “**арын ба өврийн са**” гэгч үсгийн солигдол болно.

Ж. Лувсандорж (Карлын Их Сургууль)
